МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Засгийн газрын VII байр, Энхтайваны өргөн чөлөө 51,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13340
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 81 12,
Цахим шуудан: info@mod.gov.mn,
Цахим хуудас: www.mod.gov.mn

2023.12.25 № 10/4030

танай __________-ны №__________-т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР
З.ДАШДАВАА ТАНАА

Батлан хамгаалах яамны 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 15 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д.ГАНХУЯГ

1323107647

# БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Батлан хамгаалах яамны авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, 5 зорилт, 17 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 100% хангаж ажиллалаа.

Зорилго 1: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд авлигатай тэмцэх газраас тавигдсан шторк, инфографик болон цахим сайтад тавигдсан нийтлэлийг Батлан хамгаалах яамны сайтад Төрийн захиргааны удирдлагын газартай хамтран оруулж, нийтэд мэдээлж байна. Үүнд:

-Авлигын гэмт хэрэг-2, Шүгэл үлээгч”, мөн “Алдагдах шахсан Монголын баялаг” сэдвийн хүрээнд 2023.02.17-носс 03.10-ны өдөр бэлтгэж, цахим сайтад тавьсан шторкийг өөрийн facebook цахим хуудсаараа дамжуулан хүргэлээ.

-“Авлигын гэмт хэрэг №3” сэдэвт 2023.03.14-ний өдрийн нэвтрүүлгийг 2023.03.28 өдөр;

-“Үйлийн үр хаяг андуурдаггүй” 2023.03.13-ны өдрийн шторкийг 2023.03.28 өдөр;

-“Авлигын эсрэг нэгдэе” сурталчилгааг Батлан хамгаалах яамны болон харьяа байгууллагын цахим сайтад 2023.05.29-ний өдөр, Шүгэл үлээх үйл ажиллагааг сурталчлах, уриалахтай холбогдуулан Батлан хамгаалах салбараас дэмжсэн постерийг боловсруулж, постерийг яамны facebook хуудсанд 2023.05.31-ний өдөр тус тус байршуулан ажиллалаа.

-Соёмбо редакцаар дамжуулан Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг МҮОНРТ-ийн “Эх орны төлөө” нэвтрүүлгээр олон нийтэд сурталчилсан.

-Соёмбо редакцын “Дуулга” студийн алба Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Үгүй гэж хэлээрэй”, “Авлигын эсрэг нэгдье” зэрэг уриатай нийт 2 минут 10 секундын 2 шторкийг бүтээж, нийтийн хүртээл болгож, авлигын эсрэг хууль, тогтоомж, төрийн бодлогыг сурталчиллаа.

-Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ-аас 2023.06.01-ний өдөр “Гэр бүлийн төлөө нэгдье”, “Авлигын эсрэг нэгдье” үйл ажиллагааг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд амжилттай зохион байгуулсан бол ҮБХИС-иас “Олон улсын марафон гүйлт”-д болон “Авлигын эсрэг нэгдье” үйл ажиллагааг сурталчлах аянд 100 гаруй оюутан, сонсогчийг, 2023.06.03-ны өдөр хамааруулж оролцуулсан.





-Зэвсэгт хүчний 124, 084 дүгээр ангийн хамт олон Авлигатай тэмцэх газрын УССГХ-тэй хамтран “Авлигын эсрэг нэгдье, бид хамтдаа” шторкийг хийж, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсныг Соёмбо сонинд болон яамны facebook цахим хуудсанд тус тус нийтлүүлсэн.

Авлигын эсрэг тогтмол буланг “Соёмбо” сонинд нээж нийтлэл бэлтгэн хэвлүүлж, “АТГ-ын мэргэжилтэн Г.Ихмөрөн: Авлигаас ангижрах гол хүчин зүйл нь төр иргэний хамтын хүч юм” ярилцлага, Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын хэрэг эрхлэх газраас төрийн бүх байгууллагуудад албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Батлан хамгаалах салбар ямар ажил арга хэмжээ зохион байгуулж буй талаар БХЯ-ны Хуулийн хэлтсийн шинжээч “Д.Ганзориг Авлигатай тэмцэх нь шударга ёсны үйл хэрэг” тодруулга ярилцлага, “Шударга байдлын үнэлгээгээр БХЯ тэргүүллээ” нийтлэл, “Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн ажиллалаа” зэрэг сурвалжилга, мэдээ, мэдээллийг үзэгчдийн хүртээл болгосон. (2022.02.06-ны өдрийн №20 дугаар сонин)

-“Батлан хамгаалахын төв архив”-ын www.mod.archive.gov.mn цахим хуудаст “АТГ-ын гомдол, мэдээлэл хүлээн авах утас 110” дугаарыг болон “Авлигын эсрэг нэгдье” уриалгыг тусгасан.

-Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга нь мэдээллийн самбартаа Авлигатай тэмцэх газраас гаргасан шторк, зурагт хуудас, нийтлэл зэргийг хэвлэж байршуулсан.

















- Авлигатай тэмцэх газрын УССГ хэлтсийн даргын “Авлигаас ангижрах гол хүчин зүйл” сэдэвт ярилцлагыг Соёмбо сонинд нийтэлсэн.

-“Соёмбо” редакц нь “Гэр бүлийн төлөө нэгдье”, “Авлигын эсрэг нэгдье”, “Олон улсын марафон гүйлт”, олонтой “Авлигын эсрэг нэгдье, бид хамтдаа” шторкийг хийсний зэрэгцээ олон сургалт, сурталчилгааг сурвалжилсан.

-Батлан хамгаалах яам, АНУ-ын Батлан хамгаалах Олон улсын эрх зүй судлалын хүрээлэнтэй хамтран 2023.03.06-09-ний өдрүүдэд “Захирагч, даргад хууль, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

-Үндэсний батлан хамгаалахын их сургууль нь авлигын эсрэг гэмт хэрэг, зөрчил гарч болох шалтгаан, нөхцөлийг судлан, нийт бие бүрэлдэхүүнд авлигын асуудлаас ангид байх хандлагын өөрчлөлтийг олгох, энэ талаарх мэдээллийг чөлөөтэй авах нөхцөлийг хангах, түүний хор уршгийг ухуулан таниулах, авлигын хяналтыг сайжруулах үүднээс “ҮБХИС-хууль, эрх зүйн мэдээлэл” нэртэй Facebook групп нээн 3.8 мянган гишүүнтэйгээр мэдээллээ хүргэн ажиллаж байна.

-Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын албанаас СБТГ-тай хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ЦШ-ын алба хаагчдад 2023.04.05-ны өдөр танхимаар болон цахимаар зохион байгуулж, хэлэлцүүлэгт АТГ-ын УССГХ-ийн комиссарууд оролцсон.

-Монгол Улсын Засгийн газрын “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоол, ТНБД-ын баталсан “БХЯ-ны 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хүрээнд ЦТЭ-ийн сувилагч нартай 2023.05.18-ны өдөр “Авлига, авлигын шалтгаан нөхцөл” сэдвээр Хуулийн хэлтсийн шинжээч Л.Ганзориг сургалт зохион байгуулав.

-Авлигатай тэмцэх газрын УССГХ-тэй хамтран “БХАҮН” ТӨААТҮГ-аас 2023.06.01-ний өдөр “Гэр бүлийн төлөө нэгдье”, “Гэр бүлийн төлөө нэгдье”, “Авлигын эсрэг нэгдье” үйл ажиллагааг 1000 ширхэг 0.5 литрийн цэвэр усаар

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд дэмжиж оролцсон бол Үндэсний батлан хамгаалах их сургуулиас “Олон улсын марафон гүйлт”-д болон “Авлигын эсрэг нэгдье” үйл ажиллагааг сурталчлах аянд 100 гаруй оюутан, сонсогчийг, 2023.06.03-ны өдөр хамааруулж оролцуулсан.










-Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг яамны шалган нэвтрүүлэх байранд болон харьяа байгууллага бүрт ажиллуулж, мэдээлийг сар бүр тогтмол шинэчилж хэвшсэн.




-Шүгэл ажиллагааны хүрээнд АТГ-аас уриалсан “Авлигын эсрэг нэгдье” уриалгыг мэдээллийн самбарт байрлуулсан.

-Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “5Ш” үйл ажиллагааг салбарын ажилтан, алба хаагчид болон бусад иргэд, олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Авлигатай тэмцэх нь шударга ёсны үйл хэрэг” сэдэвт ярилцлагыг Соёмбо сонины 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нийтлүүлж, ярилцлага Батлан хамгаалах яамны сайтад 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр тавигдсан.

-АТГ-аас “Шүгэл үлээх үйл ажиллагааг 2023.05.29-ний өдрөөс эхлэн улс орон даяар зохион байгуулахтай холбогдуулан БХЯ-ны болон бусад харьяа байгууллагуудын цахим, facebook сайтууд, мэдээллийн самбарт “Авлигын эсрэг нэгдэе” сурталчилгааг тус тус байршуулсан.

-“Барилга захиалагчийн алба” ТӨААТҮГ-ын ажилтан, алба хаагчид АТГ-аас бэлтгэсэн шторкуудыг өөрсдийн хуудсанд байрлуулсан.









-Алдар спорт хороо авлигатай тэмцэх газраас “Зөв зөвд шударга зөв” аянд нэгдэн олон нийтийн сүлжээг ашиглан авлигатай тэмцэх, үйл ажиллагааг сурталчлан таниулах, үнэн зөв мэдээ мэдээллийг авлигатай тэмцэх газрын цахим хуудсаар дамжуулан алдар спорт хорооны цахим хуудас, мэдээллийн самбарт






өндөржүүлэх талаар яриа хийж, үүрэг чиглэл өгч ажилласан.



-Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Таны эрх, таны оролцоо-Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” соён гэгээрүүлэх өдөрлөгийг оюутан залууст шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, авлигыг үл тэвчих үзлийг бий болгох мэдлэг, мэдээллийг өгөх, чөлөөт цагаа үр дүнтэй, бүтээлч өнгөрүүлэх, шударга байдал, ёс зүй, ёс суртахууны талаар мэдлэгтэй болгох, шударга ёсны талаарх үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, авлигын эсрэг дуу хоолойг сонсох, санал санаачилагыг дэмжих түгээн дэлгэрүүлэх зорилгоор ҮБХИС-ийн сургуулийн соёлын төвд Аюулгүй байдлын дээд сургуулийн 4 дүгээр ангийн /төгсөх курсийн/ 450 гаруй оюутнуудыг хамруулан, төлөвлөгдсөн хөтөлбөрийн дагуу зохион байгуулан ажилласан. Тус өдөрлөгт Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Н.Батчулуун, мөн хэлтсийн ахлах комиссар Б.Тэрбиш нар урилгаар хүрэлцэн ирж оролцсон.





-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль энэ онд батлагдсантай холбогдуулан уг хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр шторк бэлтгэж, facebook цахим хуудсаар хүргэсэн.

-Авлигын эсрэг нэгдье аяны хүрээнд Буруу аргаар орсон баялаг, бүтэн амьдралыг тань сүйрүүлнэ сэдвийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр бэлтгэж, цахим сайтад тавьсан шторкийг өөрийн facebook цахим хуудсаараа хүргэсэн.






Олон нийтийн сүлжээг ашиглан авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчилан таниулах, үнэн зөв мэдээ мэдээллийг бодит эх сурвалжаас түгээх зорилготой Батлан хамгаалах яам түүний харьяа байгууллагын сайт, фейсбүүк хуудсыг хөтлөн хөгжүүлэлтийг тухай бүр хийж, хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Батлан хамгаалах яамны фейсбүүк хуудасны дагагчдын тоо 43000, “Бөртэ” ТӨААТҮГ 7200, Соёмбо редакц 9100, Батлан хамгаалахын төв архив 8400, Монгол цэргийн музей 6500, Батлан хамгаалахын шүүх эмнэлэг 234, Үндэсний Батлан хамгаалахын их сургууль 8300, Зэвсэгт хүчний жанжин штаб 36000 нийт дагагчдын тоо 118,734 байна.

Авлигатай тэмцэх газраас гаргасан видео контент/шторк, мэдээ, мэдээлэл болон нийтлэл (пост)-ийг Батлан хамгаалах яам, харьяа байгууллага, Зэвсэгт хүчний жанжин штаб, нэгтгэл анги, байгууллагуудын фейсбүүк хуудаснуудад байршуулан дунджаар давхардсан тоогоор 5,538,000 хүнд хүргэсэн байна.

Зорилго 2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах.

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан танилцуулах, авлигыг үл тэвчих үзэл, шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор дараах сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:

-Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Н.Батчулуунтай хамтран 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Батлан хамгаалах яамны харьяа ЗХЖШ-ын анги, нэгтгэл, салбарын Хуулийн

асуудал хариуцсан нийт 46 офицеруудад “Авлигын нөхцөл байдал, анхаарах асуудал” сэдвээр;

-Үндэсний батлан хамгаалахын их сургуульд шинээр томилогдсон ажилтан, алба хаагч нартай 2023.06.08-ны өдөр “Авлига, авлигын шалтгаан нөхцөл”, “5 Ш” үйл ажиллагаа” сэдвээр;

-Цэргийн төв эмнэлэг Эрүүл мэндийн яамны дэргэдэх ёс зүйн хяналтын хороотой хамтран “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн харилцаа хандлага” “Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх” сэдвээр;





-“Барилга захиалагчийн алба” ТӨААТҮГ-т шинээр томилогдсон 2 ажилтан, алба хаагч, “Бөртэ” ТӨААТҮГ-т шинээр томилогдсон 34 ажилтан, алба хаагчдад “Авлига, авлигын шалтгаан нөхцөл” сэдвээр;

-Монгол улсын Засгийн газрын “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоол болон Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Батлан хамгаалах яамны 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажил, арга хэмжээний хүрээнд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн шинжээч Л.Ганзориг Цэргийн төв эмнэлгийн сувилагч нарт 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр “Авлига, авлигын шалтгаан нөхцөл” сэдвээр;





-“Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр “Авлига, авлигын шалтгаан нөхцөл” сэдвээр




- Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар А.Тунамал-Эрдэнэ, Ж.Мөнхжаргал нар 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтад Цэргийн төв эмнэлгийн 150 хүн хамрагдсан.




-БХЯ, ЗХЖШ, түүний харьяа байгууллагуудын Авлигын эсрэг асуудал хариуцсан 14 ЭБАТ-ууд 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах сургалтад хамрагдсан.




-Цэргийн төв эмнэлэг авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хичээлүүдийг хуулийн офицер 2023 оны 4, 5 дугаар сарын 7 хоног бүрийн 5 дахь өдөр 2 цагийн хугацаатай нийт 6 цагийн хичээлийг нийт бие бүрэлдэхүүнд заасан. Хичээлд нийт 90 ажилтан алба хаагч хамрагдсан.





- Монгол Улсын Гавъяат А.Гэлэгжамц 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын бие бүрэлдэхүүн авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах хүрээнд чуулгын "Хандлагын тухай", "Хамт олны эерэг харилцаа, сэтгэл зүйн эрүүл мэнд" сэдвээр;





-Батлан хамгаалахын төв архивын ажилтан, алба хаагчдыг "Авлигаас урьдчилан сэргийлэх арга замууд", "Ёс зүйн зөвлөлийн эрх зүйг идэвхжүүлэх", "Манлайлал" сэдвээр;

-"Соёмбо" редакцийн алба хаагчид Хэвлэлийн хүрээлэнгээс зохион байгуулсан "Авлигагүй сэтгүүл зүй" сэдэвт сургалт;

-Батлан хамгаалах яамны Сртатегийн бодлого төлөвлөлтийн газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/37 тоот албан бичгээр яамны бүтцийн нэгжийн дарга нарт "Шинээр томилогдсон алба хаагч "Авлига, авлигын шалтгаан нөхцөл", "Төрийн алба хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад хамруулах тухай албан бичгийг хүргүүлсэн. Тус сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр яамны 320 тоот танхимд яаманд шинээр томилогдсон нийт 13 алба хаагчдын дунд зохион байгуулав.














Зорилго 3: Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох

-Батлан хамгаалах яамнаас 2023 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендерт шалгарсан аж ахуй нэгж, байгууллагатай байгуулах гэрээнүүдэд "Талууд авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс ангид байж, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гарсан, гарах нөхцөл бүрдсэн тохиолдолд нэн даруй эрх бүхий байгууллага, этгээдэд мэдэгдэнэ." гэж нэмсэн зохицуулалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгасан. Нотломжид гэрээг бүхэлд нь бус гэрээний заалт тусгасан хэсгийг тусгасан болно.

-Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бодлого, үйл ажиллагааг Иргэд олон нийтэд сурталчлах, иргэн-цэргийн харилцаа бэхжүүлж, иргэн, аж ахуйн нэгж байгууллага руу чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа нэг нь Нийслэлийн ерөнхий боловсролын 44, 53 дугаар сургуулийн удирдлага, багш, ажилтан, ахлах ангийн 300 гаруй сурагч нарт "Эх оронч үзэл, бахархлын үнэ цэн" сэдвээр, Монголросцветмет Төрийн өмчит үйлдвэрийн

газрын 50 гаруй ажилтан албан хаагчдад “Хувь хүний хөгжил манлайлал” сэдвээр тус тус Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлөөс сургалт хийж Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, хүүхэд залуучуудыг цэрэг-эх оронч үзлээр хүмүүжүүлэх сургалт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулсан.

-Үндэсний батлан хамгаалахын их сургаалийн сонсогч, оюутан, залуусын шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх, сургуулийн орчинд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, шударга байх соёлыг түгээх зорилгоор ҮБХИС-ийн сонсогч, оюутнуудыг түшиглэн “Шударга ёсны клуб” байгуулах нээлтийн арга хэмжээг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2023 оны 10 сарын 27-ны өдрийн 16:30-17:30 цагт тус сургуулийн “Соёлын төв”-д зохион байгууллаа.




Нээлтийн арга хэмжээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Ихмөрөн, ахлах ажилтан, ахлах комиссар Б.Тэрбиш, комиссар Н.Батчулуун, М.Жамъянчойжил нар хүрэлцэн ирж, тус сургуулийн харьяа Цэргийн нэгдсэн дээд сургууль болон Аюулгүй байдлын дээд сургуулийн 1-4 курсийн 420 гаруй сонсогч, оюутнуудыг хамруулан нээлтийн арга хэмжээг хамтран зохион байгууллаа.



-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар баталсан "Батлан хамгаалах-Иргэний хяналт" тусгай дугаарын ашиглалтын журмын дагуу Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, алба хаагчидтай холбоотой асуудлаар иргэдийн санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авах "1800-1144" тусгай дугаарыг ажиллуулж байна.

Зорилго 4: Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.

-Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 1.1-д "Төрийн байгууллага, албан тушаалтан ... авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ... ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.", 5.1.1.2-т "төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшсэн байх." гэж заасан зохицуулалтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд яамны алба хаагчдаас 2023 оны 04 дүгээр сард 24 асуумжаас бүрдсэн "Авлигын эрсдэлийг үнэлэх судалгаа"-г авч, судалгааны дүнг нэгтгэн Авлигын эрсдэлтэй, авлигад өртөх магадлалтай албан тушаалын жагсаалтыг гаргасан.

-Батлан хамгаалах яам, АНУ-ын Батлан хамгаалах Олон улсын эрх зүй судлалын хүрээлэнтэй хамтран 2023 оны 03 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд "Захирагч, даргад хууль, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх нь" сэдэвт сургалтыг БХС-ын 2023 оны А/53 дугаар тушаалаар зохион байгуулсан. Сургалтад БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги байгууллагуудын хуулийн асуудал хариуцсан нийт 55 албан тушаалтан хамрагдсан бөгөөд эдгээр алба хаагчдад Авлигын эсрэг нөлөөлөл, түүний хор уршгийн талаар мэдээлэл өгч, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан танилцуулсан.

-Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн ажлын албанаас яамны СБТГ-тай хамтран "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын алба хаагчдад 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр танхимаар болон цахимаар зохион байгуулж ажилласан. Тус сургалт, хэлэлцүүлэгт Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулуун, мөн хэлтсийн комиссар Жамьянчойжил нар "Авлигын хор хөнөөл, шалтгаан нөхцөл", "Авлигын гэмт хэрэг" гэсэн сэдвээр сургалт явуулж оролцсон болно.

-Засгийн газрын "2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоол болон яамны ТНБД-ын баталсан "Батлан хамгаалах яамны 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах ажил, арга хэмжээний хүрээнд Цэргийн төв эмнэлгийн сувилагч нартай 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр "Авлига, авлигын шалтгаан нөхцөл" сэдвээр яамны СБТГ-ын Хуулийн хэлтсийн шинжээч Л.Ганзориг сургалт зохион байгуулав.

-Зэвсэгт хүчний 124, 084 дүгээр ангийн хамт олон АТГ-ын УССГХ-тэй хамтран "Авлигын эсрэг нэгдье, бид хамтдаа" шторкийг хийж, "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж, Соёмбо сонинд болон яамны facebook цахим хуудсанд нийтлүүлсэн.

-Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 1.1-д "Төрийн байгууллага, албан тушаалтан ... авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ... ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.", 5.1.1.2-т "төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшсэн байх." гэж заасан зохицуулалтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд яамны алба хаагчдаас 2023 оны 04 дүгээр сард "Авлигын эрсдэлийг үнэлэх судалгаа"-г авч, Авлигын

эрсдэлтэй, авлигад өртөх магадлалтай албан тушаалын жагсаалтыг гаргаж нэгтгэсэн.

-Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх үүднээс “Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ захиалгын төлбөрийг бэлэн мөнгөөр хийхээс татгалзан Qpay, пос машиныг нэвтрүүлэн ажиллаж байна.

-Авлигын эсрэг тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан, нөхцлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах гэж заасны дагуу батлан хамгаалах салбарт авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг тодорхойлох, таслан зогсоох, ил тод байдлыг дээшлүүлж, хүнд суртал, чирэгдлийг арилгах зорилгоор Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран “Цэргийн анги дахь ашиг сонирхол ба хүний эрхийн зөрчил” сэдвээр 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Зэвсэгт жанжин штабын харьяа хугацаат цэргийн нэгтгэл, ангиудын захирагч, эрх бүхий албан тушаалтан нарыг хамруулсан уулзалт зохион байгуулсан.



БАТЛАВ
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ХЭЛТСИЙН ДАРГА, ЭРХЭЛСЭН КОМИССАР
Х.ИХМӨРӨН

“ЦЭРГИЙН АНГИ ДАХЬ АШИГ СОНИРХОЛ БА ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ” СЭДЭВТ УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

**Уулзалтын зорилго:** Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах гэж заасны дагуу Батлан хамгаалах салбарт авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг тодорхойлох, таслан зогсоох, ил тод байдлыг дээшлүүлж, хүнд суртал, чирэгдлийг арилгах.

**Хамтран ажиллах байгууллага:** Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисс, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа хугацаат цэргийн нэгтгэл, ангиудын захирагч, эрх бүхий албан тушаалтан нар оролцоно.

**Уулзалт болох газар, огноо:** АТГ-ын Олон нийтийн төв, 1 дүгээр давхрын 106 тоот хурлын танхим, 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 09.00 -11.00 цагт.

| Хугацаа | Сэдэв | Мэдээлэл хийх албан тушаалтан |
| --- | --- | --- |
| 08:50-09:00 | Оролцогчдыг хүлээн авах | УССГХ-ийн ажилтан, комиссар Н.Батчулуун |
| 09:00-09:10 | Нээлт | УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Х.Ихмөрөн |
| 09:10-09:30 | “Батлан хамгаалах салбар дахь авлигын ерөнхий нөхцөл байдал, анхаарах асуудал” | УССГХ-ийн ахлах ажилтан, ахлах комиссар Б.Тэрбиш |
| 09:30-10:00 | “Цэргийн албан хаагчийн эрхийн хэрэгжилтийн байдал” | Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор Б.Энхболд |
| 10:00-10:30 | “Батлан хамгаалах салбар дахь авлигын эсрэг үйл ажиллагаа ба хүний эрхийг хэрэгжүүлэх нь” | Батлан хамгаалах яамны Ерөнхий хянан шалгагчийн ахлах албаны дарга, хурандаа Т.Мөнхбаяр |
| 10:30-11:30 | Асуулт, хариулт, шийдэл | |



-Аймаг, нийслэлийн цэргийн штабуудад 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Ёс зүйн хэм хэмжээ, цэргийн албаны нэр хүндийг өндөрт өргөн, батлан хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх, авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс ангид байх талаарх зөвлөмжийг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний 1в/3565 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Зэвсэгт хүчний Жанжин штабаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтуудыг Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний 42 нэгтгэл, анги байгууллагад явуулж авлигын эрсдэл үүсэх, хүний эрх зөрчигдөж болзошгүй эсэхэд дүн шинжилгээ хийж ажилласан.

Дээрх шалгалтын мөрөөр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан даалгавар 13, зөвлөмж 12, албан шаардлага 15, цахим зөвлөмж 9 хүргүүлсэн.

Зорилго 5: Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх

-“Батлан хамгаалах яамны 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Батлан хамгаалах яамны mod.gov.mn сайтад 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр байршуулсан. Тус төлөвлөгөөг яамны нийт алба хаагчдад 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр яамны дотоод сүлжээгээр танилцуулсан.






- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төсөл, хөтөлбөрийн төслийн үзэл баримтлал болон Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй 2023 оны 03 сард танилцаад, холбогдох саналыг албан бичгээр хүргүүлсэн.

-Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” тогтоол батлагдсантай холбогдуулан тус тогтоолыг сурталчлах ажлын хүрээнд “5Ш” үйл ажиллагааны талаар нийт Батлан хамгаалах яамны нийт алба хаагчдад яамны дотоод сүлжээгээр холбогдох мэдээллийг хүргүүлсэн.

-Батлан хамгаалах яам, ЗХЖШ, түүний харьяа байгууллагуудын Авлигын эсрэг асуудал хариуцсан 10 ЭБАТ-уудыг Авлигатай тэмцэх газраас 2023 оны 06 сарын 12-13-нд зохион байгуулсан “Сургагч багш”-ийн сургалтад хамруулж “Сургагч багш”-ийн гэрчилгээтэй болсон.







-Батлан хамгаалах яам, харьяа байгууллага бүр “Авлигын эсрэг 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж хэрэгжүүлсэн. Тухайлбал: -Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “БХЯ-ны 2023 оны авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөө” -Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “ЦДБЭЧ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө” -Батлан хамгаалахын төв архивын даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “БХТА-ын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”







БАТЛАН ХАМГААЛАХЫН ТӨВ АРХИВЫН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ Ж.АЛТАНГУУЛ

ХЯНАСАН:
МЭРГЭЖЛИЙН АЛБАНЫ ДАРГА,
АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЭРХЭМЗАЯА

-Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчидтай холбоотой иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний бүртгэл, шийдвэрлэлттэй танилцаж, хариуг тухай бүр хүргүүлсэн.

Төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьтай дүгнэгдэв.

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА Р.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖДИЙН БОДЛОГО, СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ДЭД ХУРАНДАА Б.ШИРНЭН